



МОНГОЛ УЛСЫН  
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН  
ГИШҮҮНИЙ ЗӨВЛӨМЖ

2023 оны 01 дугаар сарын 10

№ 05/03

Улаанбаатар хот

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ  
АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ ТАНАА

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6, 7.1.9, 7.1.11, мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1, 29 дүгээр зүйлийн 29.6.4 дэх заалтыг тус тус үндэслэн “Хан-Эко тээвэр” ОНӨААТҮГ-ын ажилтнуудын Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенц, дотоодын хууль тогтоомжоор баталгаажуулсан хөдөлмөрлөх эрх, ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаан дахь ялгаварлан гадуурхалт, дарамт, хүчирхийллээс ангид байх эрхийн хэрэгжилт болон Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтэд 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр хяналт шалгалт хийсэн.

Хяналт шалгалтыг тус байгууллагын нөхцөл байдалтай газар дээр нь танилцах, ажилтнуудаас санал асуулга авах, ярилцлага хийж, холбогдох албан тушаалтнаас тайлбар авах, баримт бичигт дүн шинжилгээ хийх, хамаарах судалгааг гаргуулан авах зэрэг аргачлалаар явууллаа.

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн “Хан-Эко тээвэр” ОНӨААТҮГ-ын захирлын 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн баталж, дотоод журмын 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт хөдөлмөрийн гэрээ байгуулах болон гэрээний хугацаа, гэрээнд тусгах гол нөхцөлийг тусгаж, ажилтантай байгуулсан байна. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14, 15, 17, 27 дугаар зүйлд тус тус заасан ажил олгогчийн үүргээ зохих ёсоор биелүүлж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар тодорхой үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэн үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийг байгууллагын жил бүрийн төсөвт суулгаж, нийт ажилтныг эрүүл мэндийн урьдчилсан үзлэг болон давтан үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулж, ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр тогтмол хангаж, ажиллаж байгаа нь сайшаалтай байна.

Хяналт шалгалтын үр дүнд анхаарч ажиллах дараах нөхцөл байдал тогтоогдож байна. Үүнд:

1. “Хан-Эко тээвэр” ОНӨААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 05 дугаар тогтоолоор байгууллагын бүтэц орон тоо, цалингийн сүлжээг шинэчлэн баталжээ. Энэхүү тогтоосон цалингийн сүлжээ нь ижил ажил үүрэг гүйцэтгэдэг бусад дүүргийн байгууллагын ажилтны цалин хөлстэй харьцуулахад бага байгаа талаар ажилтнуудтай хийсэн ганцаарчилсан ярилцлагад дурдсан, мөн нэгдсэн хяналт шалгалтаар цугларсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, харьцуулахад бага байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1.1 дэх заалтад “ижил үнэлэмжтэй ажил үүрэг гүйцэтгэж байгаа ажилтны цалин хөлсний хэмжээ адил байх” гэж заасантай нийцэхгүй байна.

2. Тус газрын нөхцөл байдалтай танилцахад ажилтан усанд орох өрөө, цайны газаргүй байна. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.15 дахь заалтад "ахуйн байр" гэж иргэн, ажилтны хөдөлмөрлөх хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн, тусгайлан төхөөрөмжилсөн хувцас солих, түр амрах, хооллох, бие засах, усанд орох, дулаацах зэрэг зориулалтын өрөө тасалгааг ойлгохоор томъёолжээ. Мөн хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.10 дахь заалтад ажил олгогч нь хэт халуун буюу хүйтэн, салхитай, хур тунадастай зэрэг задгай газар, халаалтгүй байранд ажиллаж байгаа ажилтныг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартын дагуу түр завсарлагын үед амрах, дулаацах, хоргодох зориулалтаар тоноглож тохижуулсан ахуйн байраар хангах үүрэгтэй гэж заасантай тус газрын нөхцөл байдал нийцэхгүй байна.


3. Ажилтнуудтай хийсэн ганцаарчилсан ярилцлагад "...хамгаалалтын хувцас (комбинзон)-ыг 14 хоног тутам олгох хэрэгтэй байна. Комбинзон маш хурдан урагддаг эсхүл тоос, хог шороо, үнс, нян бактер наалдаж, ахиж өмсөх боломжгүй болдог учраас ойр ойрхон солих шаардлага гардаг" гэдгийг давтан дурджээ. Иймд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15 дугаар зүйлд ажилтныг ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр үнэ төлбөргүй хангах үүргийн дагуу ажилтнуудын ажлын хувцас хэрэглэлийн чанар, хүртээмж, эдэлгээний чанар, хувцас олгох хугацаанд анхаарах шаардлагатай байна.

Цаашид дараах арга хэмжээг авч, хэрэгжүүлэх талаар Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэгт заасны дагуу Комиссын гишүүний Зөвлөмжийг хүргүүлэх нь зүйтэй байна. Үүнд:

1. Ажилтны цалин хөлс, урамшууллыг ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллагатай жишиж, нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллах;
2. Ажиллах орчныг сайжруулж, бусад хангамж (амралтын өрөө, усанд орох өрөө, цайны газар)-ийг шинээр байгуулах, ингэхдээ бусад дүүргийн тохижилт үйлчилгээний байгууллагуудын сайн туршлагыг судлах, хэрэгжүүлэх;
3. Ажилтанд ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл олгохдоо Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хорооны 2021 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор баталсан "Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл олгох" зөвлөмжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох.

Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт, үр дүнг нотлох баримтын хамт Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэгт заасны дагуу 30 хоногийн дотор ирүүлнэ үү.

ГИШҮҮН



Д.СҮНЖИД